



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

*2022 оны 08 сарын 08 өдөр*

Дугаар *100*

Амардалай

Хурдан морь унаач хүүхдийн эрх, аюулгүй  
байдлыг хангах, хамгаалах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/764 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын өндер настан 3. Содномпилийн 90 насны ойн арга хэмжээ, Монгол Улсын сайн малчин Б. Балдоржийн цол тэмдгийн мялаалгын найр, наадмыг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Мялаалгын найрын хурдан морь унаач хүүхдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах, болзошгүй зэрдэлзээс урьдчилан сэргийлэн ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Хурдан морины уралдаанч хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигч болон хурдан морь уяач, уралдааныг зохион байгуулагч талуудад хууль тогтоомж, холбогдох стандартыг сурталчлан таниулах хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нар, ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. Уралдаан тэмцээний талаарх тайлан мэдээг 2022 оны 08 дугаар сарын 19-ний дотор ирүүлэхийг ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Д.ЗОЛЖАРГАЛ